

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2020-04-27

Хурал хийсэн газар: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Монос хүнс ХК-ийн шингэн хүнсний үйлдвэрийн байрнаас шууд дамжуулалтаар цахимаар хуралдав.

Эхэлсэн цаг: 15:00

Дууссан цаг: 16:30

Хурлыг зарласан: Монос Хүнс ХК

Хурлын зохион байгуулагч бүрэлдэхүүн:

Хурлын дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Гантулга

Хурал зохион байгуулах комиссын дарга: Үйл ажиллагаа хариуцсан захирал П.Тодрол

Тооллогын комиссын дарга: Санхүүгийн менежер Э.Амарболд

Тооллогын комиссын гишүүд: Борлуулалтын албаны дарга Б.Бархас

Бизнес аналит Ц.Дөлгөөнмайдар

Тэмдэглэл хөтлөсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Цагаанхүү

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийсэн хөндлөнгийн компанийн аудитын дүгнэлтийг танилцуулах,
2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
3. Хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг танилцуулах,
4. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг танилцуулах,
5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсвийг батлах,

Монос Хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Гантулга хурлыг нээж, хуралд оролцож байгаа бүрэлдэхүүнийг танилцуулав. Хуралд ТУЗ-ийн дарга Л.Хүрэлбаатар, ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Б.Долгормаа, ТУЗ-ийн гишүүн, Аудитын хорооны гишүүн Ц.Цэцэгбадам, ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал А.Отгондарь, хурлын дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Гантулга, Хөндлөнгийн аудитын компани болох БДО Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Алтансүх, зөвлөх Г.Баянмөнх нар оролцов.

Хурлын дарга Б.Гантулга 2020 оны 02 дугаарын сарын 18 өдрийн 03/02 дугаартай “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай” тогтоолоор томилогдсон тооллогын комиссын бүрэлдэхүүнийг уншиж танилцуулаад Тооллогын комиссын дарга Э.Амарболдыг индэрт урив.

Тооллогын комиссын дарга Э.Амарболд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар зохион байгуулж байгаа нь онцлог бөгөөд хурлын вэб хуудаст нэвтрэх нууц үгээ авч бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлээр ирц бүрдэж байгаа гэдгийг дурдах нь зүйтэй юм. Тооллогын комиссын тогтоол №01 уншиж танилцуулав. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2, 67.3.8, 68.4 дахь хэсгийг тус тус үндэслэн Компанийн саналын эрх бүхий энгийн нийт 408,850,428 ширхэг хувьцаанаас 317,755,563 ширхэг хувьцаа буюу 77,72%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид энэ хуралд оролцож байгаа тул хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлын үйл ажиллагааг эхлүүлэв.

Хурлын дарга хурлын дэгийг танилцуулав. Дэгийн дагуу:

1. Монос хүнс ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг танилцуулах, тайланг Гүйцэтгэх захирал А.Отгондарь
2. Монос хүнс ХК-ийн 2019 оны аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах, тайланг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга Б.Долгормаа,
3. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлтийг танилцуулах, дүгнэлтийг ТУЗ-ийн дарга Л.Хүрэлбаатар,
4. Ногдол ашиг тараах тогтоол, ТУЗ-ийн 2020 оны төсвийн саналыг танилцуулах, ТУЗ-ийн гишүүн, Аудитын хорооны гишүүн Ц.Цэцэгбадам,
5. Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултанд хариулт өгөх,
6. Санал хураалтын дүнг танилцуулах, Тооллогын комиссын дарга Э.Амарболд,
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолыг танилцуулах, хурлыг хаах, Хурлын дарга Б.Гантулга

Хэлэлцэх асуудал 1: Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал А.Отгондарь “Монос Хүнс” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, мөн татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг танилцуулав. Тайланг тэмдэглэлд хавсаргав.

Танилцуулгад: “Монос Хүнс” ХК-ийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, үүсгэн байгуулагдсан түүх, компанийн засаглалын бүтэц зэргийг танилцуулаад 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн голлох үзүүлэлтэд тайлбар өгөв. Мөн компанийн хүний нөөц бодлого, шинэ үйлдвэрийн онцлог, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлууд болон онцлох зүйлсийн талаар танилцуулав.

Дараах асуудлын хүрээнд IPO хийх үед олон нийтэд хүргэсэн танилцуулга /проспектус/-д заагдсан үзүүлэлт болон гүйцэтгэл зарцуулалтыг харьцуулсан байдлаар мэдээлэл хүргэв. Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр босгосон ус ундааны шинэ үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмж, үйлдвэрийн процесс, шат дамжлагын мэдээллийг шууд дамжуулалтын камераар үйлдвэр дээрээс шууд бичлэгээр хүргэв.

Хэлэлцэх асуудал 2: Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн гишүүн, Аудитын хорооны дарга Б.Долгормаа “Монос Хүнс” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг болон хөндлөнгийн аудитын компани БДО аудит ХХК-аас гаргасан тайланг танилцуулав. Тайланг тэмдэглэлд хавсаргав.

Танилцуулгад: Санхүүгийн тайлангууд нь компанийн 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, тухайн өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”) -ын дагуу үнэн зөв илэрхийлсэн. Аудитын гол асуудлаа дараах байдлаар тодорхойлж дүгнэлт гаргасан байна.

1. Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

2019 оны балансын өдрийн байдлаар дахин үнэлгээний загвараар хэмжигдсэн биет болон биет бус хөрөнгийн бүлгүүдэд үнэ цэнийн бууралт байгаа эсэхэд тест гүйцэтгэхэд биет болон биет бус хөрөнгийн үнэ цэнийн тооцоолол ул үндэслэлтэй байна.

2. Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Татан төвлөрүүлсэн хөрөнгө (8.5 тэрбум төгрөг) нь үнэт цаасны танилцуулга дахь төлөвлөгөөний дагуу зарцуулагдсан.

Аудитын хорооны дарга Б.Долгормаа санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй хүснэгт дээр танилцуулав.

Хэлэлцэх асуудал 3: Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн дарга Л.Хүрэлбаатар “Монос Хүнс” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаад Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг танилцуулав. Дүгнэлтийг тэмдэглэлд хавсаргав.

Хэлэлцэх асуудал 4: Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн гишүүн, Аудитын хорооны гишүүн Ц.Цэцэгбадам 2020 оны 02 дугаар сарын 18 өдрийн 02/02 тоот “Ногдол ашиг хуваарилах тухай” Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг эх хувиар нь уншиж танилцуулав. Тогтоолыг тэмдэглэлд хавсаргав.

ТУЗ-ийн 2020 оны зардлын төсвийг танилцуулав. ТУЗ 2020 онд ТУЗ-ийн дарга 1- жилийн цалин 4,8 сая, хороодын дарга 3- жилийн цалин 12 сая, гишүүд 5- жилийн цалин 10 сая, нарийн бичиг 1- жилийн цалин 6 сая, хурал, бусад зардал 20 сая, нийт 52,8 сая төгрөгийг төсөвлөсөн саналыг танилцуулав.

Асуулт хариулт: Цахим хурлыг дамжуулж байгаа вэб хуудаст байрласан Санал асуулт талбараар орж асуултаа бичин илгээх товч дарж хариултыг асах талаар Хурлын дарга Б.Гантулга дахин тайлбар хийв.

Асуулт.№01: Налгарын Отгонхишиг: Анх 42857 ширхэг хувьцаа 70 төгрөгөөр авч байсан, гэтэл 42376 ширхэг хувьцаа орсон байна, хариу өгнө үү?

Хариулт: ТУЗ-ийн гишүүн Ц.Цэцэгбадам: Бид хувьцаа гаргаж Монголын Хөрөнгийн бирж дээр 8,5 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлэхээр төлөвлөж байсан ч 10,5 тэрбум төгрөгөөр биелсэн. Хуульд заасны дагуу 6000 ширхэгээс дээш хувьцаа авах захиалга өгсөн хувьцаа эзэмшигчийн захиалгыг тодорхой хувилж биелүүлдэг учир багассан байх, та хувьцаа авах захиалга өгсөн Брокер дилерийн компанидаа хандаж тодруулга аваарай.

Асуулт.№02: Лувсандоржийн Алтанцогт: “Экос” усны хуванцар лонхоо өөрсдөө үлээлгэдэг гэж ойлгосон. Хуванцарын зузааныг байгальд ээлтэй байлгах үүднээс нимгэн болгож болох уу?

Хариулт: Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Хувьцаа эзэмшигчийг ийм асуулт асуусанд баярлалаа. Бид усны пэт савны зузааныг жил бүр бууруулах байдлаар сав баглаагаа өөрчилж байгаа. Одоо шинээр гарсан байгаа усны бөглөөний зузааны хэмжээ буурсан, пэт савны грамм буурсан, шошго дээр дахин боловсруулах гэсэн тэмдэглэл болон хялбар тасдах боломжтой таславчийг оруулж өгсөн.

Асуулт.№03: Нямцоодолын Ганжаргал: Нэгж хувьцааны ногдол ашиг хэд бэ?

Хариулт: Хурлын дарга Б.Гантулга: Нэгж хувьцаанд 1 төгрөгний буюу нийт 408 сая төгрөгний ногдол ашиг хуваарилах тогтоолыг сая танилцуулсан. БДО аудит тайлан, 2019 оны жилийн эцсийн тайлан, ТУЗ-ийн зардал, гүйцэтгэл зэргийг хувь мэйл хаягаар илгээх гээд 6 хувьцаа эзэмшигчээс мэйл хаягаа ирүүлсэн байна.

Асуулт.№04: Баттөмөрийн Хаш-Эрдэнэ: Барилга анх ямар хэмжээтэй байснаа одоо ямар хэмжээтэй болсон бэ? Сая танилцуулсан уснууд худалдаанд гарсан уу?

Хариулт: Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Тайланд сая дурдсан байгаа, анх 800 м.кв талбайтай хоосон байшин авсан, одоо 1772 м.кв талбайтай оффис, үйлдвэр, агуулах бүхий байртай болсон. “Экос” усыг өмнө нь үйлдвэрийн хүчин чадлаас шалтгаалж борлуулах бүх цэгт хүргэж чаддаггүй, зөвхөн “Монос” эмийн сангаар худалдаалдаг байсан, шинэ үйлдвэрт үйлдвэрлэж эхэлснээр бүх худалдааны цэг, сүлжээ дэлгүүрт худалдан борлуулж байна. Мөн “Экос” усны сав баглаа боодол шинэчлэгдэн 330 мл, 500 мл, 1л гэсэн савалгаатайгаар худалдаалж байна. Хөлс орлуулагч спорт ус худалдаанд гарч амжаагүй, ирэх 7 хоногт гарна.

Асуулт.№05: Содномцэрэнгийн Баянмөнх: Шинэ хэдэн төрлийн бүтээгдэхүүн гарах бэ?

Хариулт: Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Энэ үйлдвэрт бид дандаа шингэн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. 32 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөж байгаагаас 10-аад нэр төрлийн

бүтээгдэхүүнийг гаргаад байна. Удахгүй бид бусад 20 нэр төрлийн бүтээгдэхүүнээ гаргахаар ажиллаж байна.

Асуулт.№06: Баттөмөрийн Хаш-Эрдэнэ: Шууд дамжуулалтын үеэр гараад байгаа үйлдвэр шинэ үйлдвэр мөн үү? Хэрэв мөн бол баяр хүргэе, оруулсан хөрөнгө оруулалт маань бодитоор үйлдвэр болсон байна. Шинэ үйлдвэр үзэж болох уу? Яаж үзэх бэ?

Хариулт: Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Бид хувьцаа эзэмшигчдэд шинэ үйлдвэрээ танилцуулахаар хурлаа эндээ зарлаж, хурлын өмнө үйлдвэртэй танилцах аялал зохион байгуулахаар төлөвлөөд байсан боловч Ковид-19 цар тахлаас болж боломжгүй болсон. Нөхцөл байдал хэвийн болох үед бид хувьцаа эзэмшигчиддээ үйлдвэрээ танилцуулах аяллаа хийх болно. Шууд дамжуулалтаар гарч байгаа үйлдвэр нь одоо ажиллаж байгаа манай шинэ үйлдвэр мөн.

Хурлын дарга Б.Гантулга: Хурлын дэгд заасны дагуу асуулт хариултын цаг дуусч байна. Та бүхэн асуух зүйлээ асуулт талбарт үлдээгээрэй. Бид таны мэйлээр хариултыг илгээх болно. Дэг ёсоор одоо 16 цаг 05 минут болж байна, санал хураалтын цаг эхэллээ. 10 минутын хугацаанд хувьцаа эзэмшигч та бүхэн саналаа өгөөрэй. /Цаг тоолж эхлэв/

Хурлын дарга Б.Гантулга: Ийнхүү Монос хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын саналын хүлээн авах хугацаа дууслаа. Одоо Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналыг нэгтгэх ажлаа эхлүүлж байна. Та бүхэнд асуулт хариултын цагтаа ирж амжаагүй зарим асуултаас танилцуулж, хариултыг өгье.

Асуулт.№07: Бадамжунайгийн Санжаажамц: 800м2 талбайг 1700м2 болгон өргөтгөсөн гэлээ. Нэмэгдэж буй газар ямар нэгэн хуулийн маргаан бий юу? Монос группийн эзэмшлийн газар уу, эсвэл Монос хүнс ХК-ийн эзэмшлийн газар уу?

Хариулт: Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Газрын хувьд ямар нэгэн маргаан байхгүй. Монос фарм ХХК-аас Монос хүнс ХК шилжүүлэн авч байгаа газар юм.

Асуулт.№08: Төмөбаатарын Уранжаргал: 2020-2021 онд экспортод ямар бүтээгдэхүүнээ гаргахаар төлөвлөн ажиллаж байна бэ? Экспортын гол зах зээлээ аль улсаар төлөвлөж байна?

Хариулт: Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Бид Хятад улсыг бүтээгдэхүүнээ борлуулах боломжтой гол зах зээлээ гэж төлөвлөж байна. Хятад улс руу зарим нэгэн нийлүүлэлт хийгдсэн байгаа, одоо үүсээд байгаа нөхцлөөс болж татан авалт буурсан, шингэн хүнсний үйлдвэрт шинээр үйлдвэрлэх шот савалгаатай биологийн нэмэлт бүтээгдэхүүнийг бид экспортлох төлөвлөгөөтэй байна.

Асуулт.№09: Төмөрбаатарын Уранжаргал: “Экос” усыг 20л савалгаатай гаргах боломжтой юу?

Асуулт.№10: Хуанбекын Нурбахыт: 5 литр хэмжээтэй цэвэр ус үйлдвэрлэх төлөвлөгөө байгаа юу?

Хариулт: Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Шингэн хүнсний үйлдвэр дээр 20л хэмжээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөөгүй, харин 5 литр хэмжээтэй ус савлаж үзэхээр төлөвлөж байгаа.

Асуулт №11: Лувсанпунцагийн Энхтайван: Жил бүр ногдол ашиг тараах уу?

Хариулт: ТҮЗ-ийн гишүүн Ц.Цэцэгбадам: Компанийн ногдол ашгийн бодлогод жил бүр цэвэр ашгийн 30%-ийг ногдол ашиг хэлбэрээр тараах гэж тусгасан байгаа, бид тэр бодлогоо баримтлан ажиллах болно.

Асуулт №12: Дашпунцагийн Эрдэнэсүрэн: Өнөөдрийн хурлыг нөхөн үзэх боломжтой юу?

Хариулт: Хурлын дарга Б.Гантулга: Зарим асуултын хариултыг тухай бүрд та бүхэнд мэйлээр хүргүүлэх болно. Зарим асуулт нилээн давхардаж байна.

Асуулт.№13: Нямдоржийн Чинхүслэн: Ковид-19 өвчин гарсантай холбоотой хэдэн бүтээгдэхүүн хойшлогдсон бэ?

Асуулт.№14: Ганбатын Буяндэлгэр: Ковид-19 үед ямар арга хэмжээ авч байна бэ?

Хариулт: Гүйцэтгэх захирал А.Отгондарь: 2020 оны стратеги төлөвлөгөө дээр бид борлуулалтын цэгээ нилээн нэмэгдүүлэх гэж төлөвлөж байсан. Ковид цар тахалтай холбоотой энэ асуудалд сөрөг нөлөө үзүүлж байна. Манай системд бүртгэлтэй байсан хүнсний цэгээс эхний 1-р улиралд 300 гаруй цэг дампуурсан харагдаж байгаа. Гэхдээ манай зарим бүтээгдэхүүн хүнсний цэгээр бус эмийн сангаар тараагддаг байсан учир хүнсний цэг, сүлжээгээр тараан байршуулснаар цэгээ нэмсэн байна. Санал хураалт 16 цаг 15 минутад өндөрлөж, саналын дүнг нэгтгэж эхлэв. Тооллогын комисс 16 цаг 25 минутанд санал хураалтын дүнг нэгтгэж дуусаад танилцуулав.

Хурлын дарга Б.Гантулга: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үргэлжилж байна. Тооллогын комиссын дарга Э.Амарболдыг санал хураалтын дүнгийн нэгтгэлийг танилцуулна уу гэж урья.

Тооллогын комиссын дарга Э.Амарболд: Санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулья. Тооллогын комиссын тогтоол №02 уншиж танилцуулав.

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг танилцуулав.

Нийт саналын эрхтэй хувьцааны тоо ширхэг - 408,850,429

Саналын эрхтэй хувьцааны тоо - 317,755,563

Ирцийн хувь – 77,72%

1. “Монос Хүнс” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай” санал хураалтын дүн: /урьдчилан ирүүлсэн саналын хуудас 45 ширхэг/
 - 1.1. Зөвшөөрсөн – 293,170,718 ширхэг буюу 92,3 % ;
 - 1.2. Татгалзсан - 2000 ширхэг буюу 0 % ;
 - 1.3. Түдгэлзсэн – 1287 ширхэг буюу 0 % ;
 - 1.4. Санал өгөөгүй/хүчингүй- 24,581,558 ширхэг буюу 7,7% тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
2. “Монос хүнс ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны төсвийг батлах тухай”” санал хураалтын дүн: /урьдчилан ирүүлсэн саналын хуудас 45 ширхэг/
 - 2.1. Зөвшөөрсөн – 292,964,506 ширхэг буюу 92,2 % ;
 - 2.2. Татгалзсан - 2000 ширхэг буюу 0 % ;
 - 2.3. Түдгэлзсэн – байхгүй ;
 - 2.4. Санал өгөөгүй/хүчингүй-24,789,057 ширхэг буюу 7,8% тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хурлын дарга Б.Гантулга санал асуулгын дүнд үндэслэн “Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай”, “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсвийг батлах тухай” тогтоолуудыг баталж, 16 цаг 30 минутанд уншиж танилцууллаа.

Хурлын дарга Б.Гантулга: Анх удаа цахим хэлбэрээр зохион байгуулсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай боллоо. Хурлыг хааж үг хэлнэ үү хэмээн хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн дарга Л.Хүрэлбаатар таныг индэрт урьж байна.

Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн дарга Л.Хүрэлбаатар: “Хувьцаа эзэмшигчдийн хуралд идэвхтэй оролцсон нийт хувьцаа эзэмшигч нартаа талархаж байгаагаа илэрхийлье. Хурал амжилттай болж өндөрлөлөө. Энэ далимд Монос Хүнс ХК-д итгэж хувьцааг нь эзэмшиж байгаа 4144 хувьцаа эзэмшигч нартаа талархаж байна. Монос Хүнс ХК их урт түүхтэй. Анх 1990 онд цэр ховхлох зэхмэл, бөөр

хамгаалах зэхмэл, ходоодны зэхмэл зэргийг үйлдвэрлэж эхэлсэн нь одоогийн “Энхжин” цайны эх суурь байсан юм. Энэ түүхээр тооцвол Монос Хүнс ХК нь 30 жилийн түүхтэй, “Моносфарм” ХХК-аас салж бие даасан компани болоод 7, 8 жил, хувьцаат компани болсноороо 1 жил хүрэхгүй түүхтэй компани юм. Өнөөдөр миний онцлон хэлэх зүйл бол Монос хүнс ХК-ийн хамт олон шингэн хүнсний үйлдвэрийг маш богино хугацаанд буюу 5,6 сарын дотор ашиглалтанд оруулсан явдал юм. Энэ нь компанийн хамт олны нөр их хичээл зүтгэлтэй холбоотой. Бид 6 сарын сүүлээр хувьцаат компани болсон гэхээр хагас жилийн ажлын үр дүн тайлангаа өнөөдөр та бүхэнд тавьж байна. Хэдий богино хугацаа ч ийм том үйлдвэрийг ашиглалтанд оруулж, мөн ашигтай ажиллан, ногдол ашгаа тараах шийдвэр гаргаж байгаа нь маш амжилттай явж байгаагийн илрэл гэж бодож байна. Хувьцаа эзэмшигчдийн өмнөөс “Монос Хүнс” ХК-ийн Гүйцэтгэх удирдлага, хамт олонд чин сэтгэлийн талархал дэвшүүлэхийг хүсэж байна.

Ковид 19 цар тахал гарсан энэ хүнд хэцүү үе тохиож байгаа ч Монос хүнс компанийн хамт олон олон сайхан шинэ бүтээгдэхүүн хийж байна. Ялангуяа эрдэс нөхөгч спорт усыг хэрэглэгчид их өндөрөөр үнэлж байна. Мөн “Tastea” цай зэрэг олон сайхан бүтээгдэхүүнийг амжилттай хийж хүнд хэцүү үеийг амжилттай давж, хувьцаа эзэмшигчдийнхээ итгэлийг алдахгүй ажиллана гэдэгт найдаж байна. Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигч та нартаа баярлалаа”

Хурлын дарга Б.Гантулга: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хааж үг хэлсэн ТУЗ-ийн дарга Л.Хүрэлбаатарт баярлалаа. Хуралд идэвхтэй оролцсон нийт хувьцаа эзэмшигч нартаа баярлалаа. Хурлын үйл ажиллагаа хаасныг мэдэгдье гэснээр хурал 16 цаг 40 минутанд дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.ЦАГААНХҮҮ

ТЭМДЭГЛЭЛ ХЯНАСАН:

ХУРЛЫН ДАРГА..... Б.ГАНТУЛГА

